

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгоны ТТЗ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2024/02/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг:
erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг:
tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг:
davaanyamb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10-11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11-12
3.5 Төсвийн төлөвлөлт гүйцэтгэл.....	12-15
4. Аудитын тайлан	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. Аудитын илрүүлэлт	19
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	19-20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ТТЗ	Төсвийн Төвлөрүүлэн Захирагч



ХӨВСГӨЛ АЙМГИЙН АЛАГ-ЭРДЭНЭ
СУМЫН ХАТГАЛ ТОСГОНЫ ЗАХИРАГЧ
А.БАТТУШИГ ТАНАА

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.25 № 01/265
танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Төсвийн төвлөрүүлэн захирагийн хяналтад байгаа байгууллагуудын үндсэн хөрөнгийн дансанд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 61.5 сая төгрөгийн хөрөнгө, шилжүүлэн авсан 491.07 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 1.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 55.1 сая төгрөгийн бусад хөрөнгийг бүртгэж үндсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь 14.3 сая төгрөгөөр, аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 10.8 сая төгрөгөөр, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 4.2 сая төгрөгөөр тус тус тасалснаас харахад Төсвийн тухай хуульд заасан үүргээ бүрэн биелүүлж ажиллаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Хатгал тосгоны Захирагч нь аймгийн Засаг даргатай 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 6 зорилт 78 арга хэмжээний хүрээнд батлуулж, хэрэгжилтийг 88.1 хувьтай биелүүлж ажилласан байна.

9724040663

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	/Мянган төгрөгөөр/	
			2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		373,761.3	601,029.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	277,997.4	463,034.2
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	95,763.9	137,994.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,817,141.8	2,273,988.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	1,817,141.8	2,273,988.6
39200	Биет хөрөнгө		1,705,158.9	2,160,964.6
39300	Биет бус хөрөнгө	13	111,982.8	113,024.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		2,190,903.1	2,875,017.7
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		2,190,903.1	2,875,017.7
51	Засгийн газрын хувь оролцоо		2,190,903.1	2,875,017.7
51100	Засгийн газрын оруулсан капитал		338,189.4	338,189.4
51200	Хуримтлагдсан үр дүн		1,659,235.9	2,343,350.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		193,477.7	193,477.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		2,190,903.1	2,875,017.7

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	/Мянган төгрөгөөр/	
		2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,061,785.6	1,828,383.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	517,618.3	626,968.3
110	Орлогын албан татвар	277,578.0	381,720.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	291,510.3	398,363.7
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-13,932.3	-16,642.9
113	Хөрөнгийн албан татвар	33,484.6	33,491.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	206,555.7	211,755.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	152,900.5	714,094.6
120	Нийтлэг татварын бус орлого	152,900.5	710,094.6
121	Хөрөнгийн орлого	0.0	4,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	391,266.7	487,320.9
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	959,375.2	1,119,643.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	959,375.2	1,119,643.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	865,788.3	1,119,018.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	342,318.0	298,818.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,208.5	39,519.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	138,073.5	42,733.4
2104	Хангамж, бараа материалын зардал	35,099.0	164,607.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	77,305.0	10,879.9
2107	Томилолт, зочны зардал	2,602.0	883.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	70,615.9	393,056.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	159,566.4	168,520.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	93,586.8	625.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	102,410.4	708,740.8
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,541,406.7	24,626.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-3,438,996.3	684,114.6

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

				/Мянган төгрөгөөр/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31		
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	967,140.9	1,246,998.1		
11	ТАТВАРЫН ОРЛОГО	517,618.3	626,968.3		
110	Орлогын албан татвар	277,578.0	381,720.9		
1100	Хувь хүний орлогын албан татвар	291,510.3	398,363.7		
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-13,932.3	-16,642.9		
113	Хөрөнгийн албан татвар	33,484.6	33,491.8		
118	Бусад татвар, төлбөр, хураамж	206,555.7	211,755.7		
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	19,539.3	16,076.3		
1181	Газрын төлбөр	0.0	11,690.7		
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	187,016.4	183,988.7		
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	58,150.9	132,709.0		
120	Нийтлэг татварын бус орлого	58,150.9	128,709.0		
121	Хөрөнгийн орлого	0.0	4,000.0		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	391,371.7	487,320.9		
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	847,638.9	1,000,487.9		
21	УРСГАЛ ЗАРДАЛ	847,638.9	1,000,487.9		
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	739,059.6	870,513.4		
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	366,185.7	323,386.8		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,442.8	46,467.2		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	141,798.2	28,485.7		
2104	Хангамж, бараа материалын зардал	63,895.0	107,949.5		
2105	Нормативт зардал	0.0	4,985.0		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	68,776.1	11,796.0		
2107	Томилолт, зочны зардал	2,602.0	883.0		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,791.6	324,799.3		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,568.1	21,760.8		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	108,579.3	129,974.6		
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	119,502.0	246,510.2		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	7,086.0	61,473.4		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,086.0	61,473.4		
2200	Дотоод эх үүсвэрээр	7,086.0	61,473.4		
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-7,086.0	-61,473.4		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	112,416.0	185,036.8		
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	165,581.4	277,997.4		
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	277,997.4	463,034.2		

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/Мянган төгрөгөөр/	
Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч		
1	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	5,671,536.6	0.0	5,671,536.6		
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-41,637.2	0.0	-41,637.2		
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,629,899.4	0.0	5,629,899.4		
9	Тайлант үеийн үр дүн	-3,438,996.3	0.0	-3,438,996.3		
10	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,190,903.1	0.0	2,190,903.1		
11	2023 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	2,190,903.1	0.0	2,190,903.1		
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,190,903.1	0.0	2,190,903.1		
19	Тайлант үеийн үр дүн	684,114.6	0.0	684,114.6		
20	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,875,017.7	0.0	2,875,017.7		

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,181,760.5	952,424.2	229,336.3	80.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,181,760.5	952,424.2	229,336.3	80.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	973,566.1	822,831.1	150,735.0	84.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	407,344.3	298,818.0	108,526.3	73.4
210101	Үндсэн цалин	288,874.3	182,949.8	105,924.5	63.3
210102	Нэмэгдэл	118,470.0	85,792.1	32,677.9	72.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.0	7,990.0	-7,990.0	
210104	Урамшуулал	0.0	22,086.0	-22,086.0	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,792.3	39,519.6	3,272.7	92.4
210201	Тэтгэврийн даатгал	20,723.2	20,565.6	157.6	99.2
210202	Тэтгэмжийн даатгал	9,865.7	8,133.9	1,731.8	82.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,583.3	1,412.4	170.9	89.2
210204	Ажилгүйдлийн даатгал	2,484.3	1,994.4	489.9	80.3
210205	Эрүүл мэндийн даатгал	8,135.8	7,413.3	722.5	91.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	228,594.5	226,998.7	1,595.8	99.3
210301	Гэрэл, цахилгаан	49,812.5	45,194.4	4,618.1	90.7
210302	Түлш, халаалт	154,112.0	158,595.0	-4,483.0	102.9
210303	Цэвэр, бохир ус	24,670.0	23,209.3	1,460.7	94.1
2104	Хангамж, бараа материалын зардал	51,527.0	46,694.0	4,833.0	90.6
210401	Бичиг хэрэг	8,000.0	8,000.0	0.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	29,646.7	25,181.8	4,464.9	84.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,500.0	3,480.2	19.8	99.4
210404	Ном, хэвлэл	80.0	48.0	32.0	60.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,300.3	8,984.0	316.3	96.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000.0	1,000.0	0.0	100.0
2105	Нормативт зардал	5,000.0	4,985.0	15.0	99.7
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,000.0	4,985.0	15.0	99.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	94,250.0	92,164.4	2,085.6	97.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,000.0	18,867.9	132.1	99.3
210602	Тавилга	5,000.0	5,000.0	0.0	100.0
210604	Урсгал засвар	70,250.0	68,296.5	1,953.6	97.2
2107	Томилолт, зочны зардал	1,500.0	883.0	617.0	58.9
210702	Дотоод албан томилолт	1,500.0	883.0	617.0	58.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	114,258.0	96,340.0	17,918.0	84.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	111,408.0	93,632.0	17,776.0	84.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	550.0	550.0	0.0	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	300.0	232.1	68.0	77.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	350.0	350.0	0.0	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	250.0	176.0	74.0	70.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000.0	1,000.0	0.0	100.0
210807	Газрын төлбөр	400.0	400.0	0.0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,300.0	16,428.5	11,871.5	58.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,800.0	15,928.5	11,871.5	57.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500.0	500.0	0.0	100.0

Хатгал тосгоны ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	208,194.4	129,593.1	78,601.4	62.2
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	207,569.4	128,968.1	78,601.4	62.1
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	207,569.4	128,968.1	78,601.4	62.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	625.0	625.0	0.0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	625.0	625.0	0.0	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,181,760.5	980,132.2	201,628.3	82.9
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	145,406.1	137,406.1	8,000.0	94.5
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	145,406.1	137,406.1	8,000.0	94.5
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	839,221.3	842,726.1	-3,504.8	100.4
320001	Орон нутгийн төсвөөс	839,221.3	842,726.1	-3,504.8	100.4
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	197,133.1	0.0	197,133.1	0.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	197,133.1	0.0	197,133.1	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	62,163.3	-62,163.3	#DIV/0!
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	89,871.3	-89,871.3	#DIV/0!
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	39	39	0	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	19	19	0	100.0
620001	Удирдах ажилтан	4	4	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	7	7	0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	8	8	0	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	19	19	0	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8	8	0	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8	8	0	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	3	3	0	100.0

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	/Мянган төгрөгөөр/ Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,325.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,325.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,325.6
2104	Хангамж, бараа материалын зардал	4,653.1
210401	Бичиг хэрэг	539.0
210402	Тээвэр, шатахуун	4,114.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,672.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,672.5
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,325.6
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,325.6
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,255.6
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	70.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Хатгал тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагч нь стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжийн хэрэгжилт, хөтөлбөр, төслийн биелэлт зэргийг Засаг даргын дэргэдэх тасаг, алба, албан байгууллага, аж ахуйн нэгжид хэрхэн хэрэгжиж байгааг хянах, шалгах, зохицуулах, чиглэл өгөх, мэдээлэл авах зэрэг эрхтэйгээс гадна дээрх байгууллагаар дамжуулан мэдээллийг цуглуулж хяналт шинжилгээ хийх дүгнэлт гаргах үүрэгтэй ажилладаг орон нутгийн төсвийн захирагч юм.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37-д төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг төсвийн төвлөрүүлэн захирагч гэж заасан байна.

Хатгал тосгоны Захирагчийн ажлын алба нь 2023 онд дараах зорилтуудыг тавьж ажилласан байна. Үүнд:

- Иргэдэд үзүүлэх үйлчилгээ, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг тооцон гаргах
- Ард иргэдэд чиглэсэн үйлчилгээг хөнгөн шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилт
- Хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлт, байгаль орчны талаар байгууллагын стратеги зорилт
- Эдийн засаг, төсөв санхүү, орлого татвар, худалдан авах ажиллагааны талаар байгууллагын стратегийн зорилт
- Нийгмийн халамж, иргэний бүртгэл, нийгмийн даатгалын талаар байгууллагын стратеги
- Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах зэрэг зорилтуудыг давьж хэрэгжүүлэн ажилласан байна.

ТТЗ-ийн хяналтад тосгоны Захирагчийн ажлын алба, тосгоны ОНХС, төрийн сангийн тайлан, Хатгал цахир ТБОНӨҮГ-ын тайлан нийт 4 төсвийн шууд захирагч, 1 тусгай сангийн тайлан нэгтгэгдэж байна

Хатгал тосгоны Захирагч нь аймгийн Засаг даргатай 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 6 зорилт 78 арга хэмжээний хүрээнд батлуулж, хэрэгжилтийг 88.1 хувьтай биелүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад хууль тогтоомж журам зааврыг мөрдөн ажилласан байна.

Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар:

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 36 дугаар зүйлийн 36.6-д заасны дагуу Тосгоны захирагчийн 2023 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн А/94 дүгээр захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналтын баг байгуулсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн бүртгэл, ашиглалт, орон нутгийн орлогын гүйцэтгэл, худалдан авах ажиллагаа, шилэн дансны мэдээлэл, урсгал засварын зардлаар хийгдсэн ажил зэрэг үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Төрийн сангийн дотоод хяналтын талаар: Аймгийн санхүү төрийн сангийн хэлтсээс Хатгал тосгоны төрийн сангийн 2023 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 2023 оны 08 дугаар сарын 31-ны өдрийн хоорондох үйл ажиллагаанд хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Тус хяналтаар төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ гаргалт, “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”-ын хэрэгжилт нэмэлт санхүүжилтийн эрх олголт, орлогын хаалт, системийн хяналт, төлбөр тооцооны хяналт, гарын үсгийн баталгаа, дансны бичилтүүд, төсвийн байгууллагын “мөнгөн кассын үйл ажиллагааны журам”-ын хэрэгжилт, баримтын бүрдэл зэрэгт хяналт хийсэн байна.

Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах хугацаатай 7 зөвлөмжийг өгсөн бөгөөд алдаа, зөрчлийг арилгаж ажилласан байна.

Хатгал тосгоны төсвийн байгууллагуудын Төсвийн талаарх хяналтыг санхүүгийн алба хэрэгжүүлж байна. Бүх ажил гүйлгээг цахимаар гүйцэтгэж байгаа бөгөөд төрийн сангийн төлбөр тооцооны системээр хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна. Төрийн сангийн төлбөр тооцоог цахимаар гүйцэтгэх болсноор анхан шатны баримтыг бүрэн оруулсны дараа ажил гүйлгээ баталдаг тул баримтын бүрдүүлэлт сайжирсан байна.

Дотоод аудит /аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах/ дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хатгал тосгоны ТТЗ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хатгал тосгоны ТТЗ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2005 оны 341 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах зааврын”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 684.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
			3=2-1
Мөнгөн хөрөнгө	277,997.4	463,034.2	185,036.8
Авлага	0	0	0
Бараа материал	95,763.9	137,994.9	42,231
Урт хугацаат зээл	0	0	0
Үндсэн хөрөнгө	1,817,141.8	2,273,988.6	456,846.8
Нийт хөрөнгө	2,190,903.1	2,875,017.7	684,114.6

Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,190,903.1	2,875,017.7	684,114.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,190,903.1	2,875,017.7	684,114.6

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгийн үлдэгдэл бараа материал, үндсэн хөрөнгүүд өссөн үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 185.0 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд Орон нутгийн ерөнхий орлогын дансанд 362.7 сая төгрөг, ОНХС-ийн дансанд 89.8 сая төгрөг, Хатгал Цахир ОНӨҮГ-н дансанд 10.3 сая төгрөг нийт 463.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
2. Бараа материалын дансны үлдэгдэл 42.2 сая төгрөгөөр нэмэгдэхэд хяналтад байгаа байгууллагуудын төсвийн хөрөнгөөр худалдан авсан 122.2 сая төгрөг, үнэ төлбөргүй шилжүүлсэн 26.4 сая төгрөг нийт 148.6 сая төгрөгийн бараа материалаар нэмэгдэж, 106.4 сая төгрөгийн материалыг зарцуулж данснаас хассан нь нөлөөлсөн байна.
3. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,273.9 сая төгрөг болж 456.8 сая төгрөгөөр өсөхөд ЗДТГ давсан орлогоор шаардлагатай компьютер техник хэрэгсэл, тавилга худалдан авсан. Азын хөгжлийн банкны санхүүжилтээр цэвэрлэх байгууламжид ашиглуулах зориулалтаар 479.6 сая төгрөгийн үнэтэй 3 авто машин үнэ төлбөргүй хүлээж авсан нь тус тус нөлөөлсөн байна. Тайлант хугацаанд хяналтад байгаа байгууллагуудын үндсэн хөрөнгийн дансанд 136.7 сая төгрөгийн элэгдэл бодогдсон байна.

Харьяа байгууллагын алдааны талаар: Хөрөнгө оруулалтаар ирсэн 185.0 сая төгрөгийн үнэтэй Бохир ус соруулах автомашиныг орлого авч хөрөнгөнд бүртгээгүй. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.5.бүх орлого гэсэн заалттай нийцээгүй тул аудитын хугацаанд хөрөнгийг орлогод авч залруулга хийлгэсэн.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 463.0 сая төгрөг болж, өмнөх оноос 185 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/Мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн сангийн харилцах	274,304.1	452,641.7	178,337.6
Арилжааны банк дахь харилцах	3,693.3	10,392.5	6,699.2
Дүн	277,997.4	463,034.2	185,036.8

Эх сурвалж: Хатгал тосгоны ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 452.7 сая төгрөг нь төрийн сангийн дансанд, 10.4 сая төгрөг нь арилжааны банканд байршиж байна.

Аудитын илрүүлэлт: Аудитаар мөнгөн хөрөнгийн данстай холбоотой алдаа зөрчил илрээгүй.

3.5.2 Авлага

Тайлант онд авлага үүсгээгүй байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилж төлсөн зардал гараагүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 137,9 сая төгрөг болж, өмнөх оноос 42.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/Мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Хангамжийн материал	94,293.9	133,944.9	39,651.0

Бичиг хэргийн материал	3,107.1	6,176.1	3,069.0
Аж ахуйн материал	2,148.0	13,475.4	11,327.4
Түлш, шатах тослох материал	30,612.0	39,208.0	8,596.0
Барилгын засварын материал	12,816.3	16,004.4	3,188.1
Бусад хангамжийн материал	45,610.5	59,081.0	13,470.5
Мал амьтад	1,470.0	4,050.0	2,580.0
Дүн	95,763.9	137,994.9	42,231.0

Эх сурвалж: Хатгал тосгоны ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх онд 95.7 сая төгрөг байсан бөгөөд хангамжийн материал 39.6 сая төгрөг, аж ахуй материал 11.3 сая төгрөг түлш, шатах тослох материал 8.5 сая төгрөг Бусад хангамжийн материал 13.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалт хийгдээгүй.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 2,273.9 сая төгрөг болж, өмнөх оноос 456.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/Мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	1,705,158.9	2,160,964.6	455,805.7
Барилга, байгууламж, орон сууц	1,387,558.1	1,404,621.0	17,062.9
Авто-тээврийн хэрэгсэл	251,001.8	730,601.8	479,000.0
Машин тоног төхөөрөмж(компьютер)	107,011.8	125,660.1	18,648.3
Тавилга, аж ахуйн эд хогшил	19,095.0	23,411.0	4,316.0
Бусад үндсэн хөрөнгө	403,192.2	476,141.0	72,948.8
Биет бус хөрөнгө	111,982.8	113,024.0	1,041.2
Программ хангамж	790.8	1,860.8	1,070.0
Бусад биет бус хөрөнгө	111,192.0	111,192.0	-
Дүн	1,817,141.8	2,273,988.6	456,846.8

Эх сурвалж: Хатгал тосгоны ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,160.9 сая төгрөг болж өсөхөд Авто тээрийн хэрэгсэл 479.0 сая төгрөгөөр, машин тоног төхөөрөмж 18.6 сая төгрөгөөр, Тавилга эд хогшил 4.3 сая төгрөгөөр, бусад хөрөнгө 72.9 сая төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

Аудитаар үндсэн хөрөнгийн данс бүртгэлтэй холбоотой алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

3.5.7 Өр төлбөр

Өр төлбөр үүсээгүй байна.

3.5.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,875.0 сая төгрөг болж, өмнөх оноос 684.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №-7. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	338,189.4	338,189.4	-
Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	338,189.4	338,189.4	-
Хуримтлагдсан үр дүн	1,659,235.9	2,343,350.6	684,114.7
Өмнөх үеийн үр дүн	5,098,232.7	1,659,235.9	(3,438,996.8)
Тайлант үеийн үр дүн	(3,438,996.3)	684,114.6	2,754,881.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	193,477.7	193,477.7	-
Дүн	2,190,903.1	2,875,017.7	684,114.6

Эх сурвалж: Хатгал тосгоны ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл нэмэгдэхэд тайлант үеийн үр дүн 684.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Орлогын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт 1,828.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж тайлагнасан байна. Тайлант онд бүрдүүлсэн орлогыг өмнөх онтой харьцуулахад 776.5 сая төгрөгөөр буюу 58 хувиар өссөн байна.

Хүснэгт №-8 Санхүүгийн үр дүнгийн нийт орлого

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/мянган төгрөгөөр/	
			зөрүү	Хувь
Татварын орлого	517,618.3	636,968.3	119,350.0	23
Татварын бус орлого	152,900.5	714,094.6	561,194.1	367
Тусламж санхүүжилтийн орлого	391,266.7	487,320.9	96,054.2	25
Нийт дүн	1,061,785.6	1,828,383.6	766,598.0	94.2

Нийт орлогын дүн өссөн шалтгаан нь татварын бус орлого өмнөх оноос 561.1 сая төгрөгөөр өссөн, албан хаагчдын цалин хөлс бараа материалын үнэ нэмэгдсэнтэй холбоотой санхүүжилтийн эх үүсвэр нэмэгдсэн зэрэг нөлөөлсөн байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 1,114.3 сая төгрөгийн орлогын давхардсан 6 гүйлгээ, мөнгөн гүйлгээний тайланд 1,114.3 сая төгрөгийн орлогын давхардсан 7 гүйлгээг хоорондын тооцоо дансаар устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

Зардлын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар тайлант онд 1,119.6 сая төгрөгийн зардлыг хүлээн зөвшөөрч тайлагнасан байна. Өмнөх онтой харьцуулахад 160.2 сая төгрөгөөр буюу 17 хувиар өссөн байна.

Хүснэгт №-9 Санхүүгийн үр дүнгийн нийт зардал

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/мянган төгрөгөөр/	
			зөрүү	Хувь
Бараа ажил үйлчилгээний зардал	865,788.3	1,119,018.0	253,229.7	30
Урсгал шилжүүлэг	93,586.8	625.0	-92,961.8	99.3
Үйл ажиллагааны зардлын дүн	959,375.2	1,119,643.0	160,267.9	17

Эх сурвалж: Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Нийт зардлын дүн өсөхөд бараа ажил үйлчилгээний зардал 253.2 сая төгрөгөөр өссөн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 1,114.3 сая төгрөгийн зарлагын давхардсан 7 гүйлгээ, мөнгөн гүйлгээний тайланд 1,114.3 сая төгрөгийн зарлагын давхардсан 7 гүйлгээг хоорондын тооцоо дансаар устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны төсвийн төслийг харьяа байгууллагуудын хүрээнд нэгтгэн боловсруулж орон нутгаас санхүүжүүлэх Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн байгууллагуудын тогтмол зардлыг тусгаж дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн нийт зардлыг 1,034.6 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Уг төсвийн саналаас 164.3 сая төгрөгөөр бууруулж 870.3 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь Захирагчийн ажлын албаны уурын зууханд их засвар хийхээр төлөвлөсөн зардал хасагдсантай холбоотой байна.

Алаг-Эрдэнэ сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 82 дугаар тогтоолоор сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрт зориулан 870.3 сая төгрөгийн төсөв баталснаас 706.6 сая төгрөгийг урсгал зардалд, 164.3 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 114.3 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, санхүүгийн дэмжлэгээс 209.8 сая төгрөгийг, сумын орон нутгийн орлогоос 478.7 сая төгрөгийг, давсан орлого дансны үлдэгдлээс 67.5 сая төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр анх баталсан байна.

Тайлант онд Алаг-Эрдэнэ сумын ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 28-ний өдрийн 02 дугаар тогтоолоор төсөвт 311.5 сая төгрөгийн нэмэх тодотгол хийж төсвийг 1,181.7 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн орлогын гүйцэтгэл

Гүйцэтгэлээр Төсөвт байгууллагын дансны үлдэгдлээс 197.1 сая төгрөгийг, орон нутгийн орлогоос 626.9 сая төгрөгийг, орон нутгийн хөгжлийн сангаас 145.4 сая төгрөгийг, санхүүгийн дэмжлэгээс 313.2 сая төгрөгийг нийт 1,282.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Сумын төсвийн орлого бүрдүүлэлт.

Алаг-Эрдэнэ сумын ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 02 дугаар тогтоолд зааснаар Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 484.2 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна. Гүйцэтгэлээр 626.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөө 129.5 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт №-10 Төвлөрүүлэх орлого

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
			Зөрүү	Хувь
1.1.Татварын орлого	484,213.6	626,968.3	142,754.7	129.5
а. Хүн амын орлогын албан татвар	286,334.0	381,720.9	95,386.9	133.3
Хувиараа аж ахуй эрхэлсний орлого /ИОТ/	5,500.00	8,763.80	3,263.8	159.3
Цалин хөлс түүнтэй адилтгах орлого /Суутган1/	251,000.00	328,724.50	77,724.5	131.0
ХХОАТ-н хөнгөлөлт	-16,474.00	-16,642.90	-168.9	101.0
Шууд бус орлого	2,550.00	1,261.80	-1,288.2	49.5
Мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого	32,000.00	36,558.60	4,558.6	114.2
Бичил үйл ажиллагааны ОАТ	11,758.00	23,054.90	11,296.9	196.1
б. Хөрөнгийн татвар	30,988.0	33,491.7	2,503.7	108.1
Үл хөдлөх хөрөнгө	9,488.0	11,102.9	1,614.9	117.0
Галт зэвсгийн албан татвар	2,000.0	2,310.0	310.0	115.5
Малын тоо толгойн албан татвар	19,500.0	20,078.6	578.6	103.0
в. Бараа үйлчилгээний бусад татвар	166,891.6	211,755.7	44,864.1	126.9
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	12,800.0	740.0	-12,060.0	5.8
Улсын тэмдэгтийн хураамж /512/	5,300.0	6,208.9	908.9	117.1
Байгалийн ургамал ашигласны төлбөр	85.0	90.0	5.0	105.9
Хүн амын унд ахуйн хэрэгцээний зориулалтаар ашигласан усны төлбөр	500.0	500.0	0.0	100.0
Ойгоос мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	138,246.6	183,398.7	45,152.1	132.7
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	9,960.0	9,127.4	-832.6	91.6
Газрын төлбөр/100/	-	30.2		
Дуудлага худалдаа		11,660.5	11,660.5	
1.2 Татварын бус орлого	17,800.0	36,312.0	18,512.0	204.0
Татварын бус хүү торгууль	15,800.0	32,312.0	16,512.0	204.5
Хөрөнгө худалдсаны орлого	2,000.0	4,000.0	2,000.0	200.0

Эх сурвалж: Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Хатгал тосгоны орон нутгийн орлого 142.7 сая төгрөгөөр давж биелэхэд цалин хөлсний албан татварын орлого 77.7 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлого 11.2 сая төгрөгөөр, газрын төлбөрийн албан татвар 11.6 сая төгрөгөөр Ойн нөөц ашигласны албан татвар 45.1 сая төгрөгөөр тус тус давж биелсэн нь нөлөөлсөн байна.

Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл:

ХХОАТ-ын орлого 0.2 сая төгрөгөөр, Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны татвар 12.1 сая төгрөгөөр, шууд бус орлогын албан татвар 1.3 сая төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 0.9 сая төгрөгөөр нийт 14.3 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон

тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Орлого тасарсан шалтгаан:

- Хатгал тосгонд хатуу хучилттай зам тавих ажил гүйцэтгэгч Бээжин юни констракшин ХХК-нь санхүүжилтгүйн улмаас тосгоны төсөвт төвлөрүүлэх Түгээмэл тархацтай ашигт малтмалын татвар 12 сая төгрөгийг төлөөгүй
- Хог хаягдлын үйлчилгээний хураамж 0.9 сая төгрөгөөр тасарсан нь Хатгал цахир ОНӨААТҮГ-н хог хаягдлын хураамж дутуу төлөгдсөн.
- Шууд бус орлогын албан татвар 1.3 сая төгрөгөөр тасарсан нь Иргэний газрын эрх шилжүүлэх орлогоос суутгах татварыг Газрын төлбөрийн дансанд төвлөрүүлэх болсон зэргээс шалтгаалсан байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд аймагт төвлөрүүлэх орлогыг 43.2 сая төгрөгөөр төлөвлөж 34.7 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 8.4 сая төгрөгөөр буюу 19.5 хувиар тасалсан байна.

Хүснэгт №-11: Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
1	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	10,000.0	1,573.6	-8,426.4	15.7
2	Авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар	13,500.0	15,239.9	1,739.9	112.9
3	Зам ашигласны төлбөр	4,000.0	4,674.0	674.0	116.9
4	Газрын үл хөдлөх хөрөнгийн татвар	450.0	0.0	-450.0	0.0
5	Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр	15,230.0	13,284.5	-1,945.5	87.2
Нийт дүн		43,180.0	34,772.0	-8,408.0	80.5

Эх сурвалж: Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл: Аж ахуй нэгжийн орлогын албан татварын орлогыг 8.4 сая төгрөг, Газрын дуудлага худалдааны орлогыг 0.5 сая төгрөг, Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлогыг 1.9 сая төгрөг нийт 10.8 сая төгрөгөөр тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 21.5 сая төгрөгөөр төлөвлөж 20.1 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж, 1.4 сая төгрөгөөр тасалсан байна.

Хүснэгт №-12: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	4,486.2	4,507.1	20.9	100.5
2	Дотоод бараа үйлчилгээний НӨАТ	16,200.3	11,961.3	-4,239.0	73.8
3	Агаарын бохирдлын төлбөр	780.0	2,229.1	1,449.1	285.8
4	Ус бохирдуулсны төлбөр		1,397.2	1,397.2	
Нийт дүн		21,466.5	20,094.7	-1,371.8	93.6

Эх сурвалж: Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга.

Орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл: Дотоодын бараа үйлчилгээний НӨАТ-ын орлогыг 4.2 сая төгрөгөөр тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Төсвийн зарлагын талаар:

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрт зориулан 1,181.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 973.6 сая төгрөгийг бараа ажил үйлчилгээний зардалд, 208.2 сая төгрөгийг урсгал шилжүүлгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 952.4 сая төгрөг буюу 81.6 хувьтай байгаа нь урсгал шилжүүлгийн зардлыг 78.6 сая төгрөгөөр бараа үйлчилгээний зардлыг 150.7 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна. Төсвийн хэмнэлтийг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 108.5 сая төгрөг
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 3.2 сая төгрөг
- Байр ашиглалттай холбоотой зардал 1.6 сая төгрөг
- Хангамж, бараа материалын зардал 4.8 сая төгрөг
- Урсгал засварын зардал 2.0 сая төгрөг
- Томилолт 0.6 сая төгрөг
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 17.9 сая төгрөг
- Бараа үйлчилгээний бусад зардал 11.8 сая төгрөг
- Урсгал шилжүүлгийн зардал 78.6 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх 14 төсөл арга хэмжээнд 207.5 сая төгрөг батлагдсанаас 12 төсөл арга хэмжээнд 128.9 сая төгрөгийг зарцуулж 83.4 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна. Энэ төсөвт өртөг хүрэлцээгүй учир Гүний худаг гаргах, Гудамжны гэрэлтүүлгийн засвар үйлчилгээ зэрэг арга хэмжээ тус тус хэрэгжээгүйтэй холбоотой байна.

Тосгоны захирагчийн хөтөлбөрийн хэрэгжилт 952.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 80.6 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ТТЗ-ийн харьяа байгууллагууд нь дээд шатны төсөв захирагчаас 12.2 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 0.1 сая төгрөг, нийт 12.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Гүйцэтгэлээр хангамж бараа материалын зардалд 4.7 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 7.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2023 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

Худалдан авах ажиллагааны үр дүнгийн талаар

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ТТЗ-ийн 2023 оны төсөвтэй хамт батлуулсан байна.

Тайлант онд Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн багцад нийт 626.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 42 бараа ажил үйлчилгээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажилласан байна. Худалдан авах ажиллагааг зохион байгуулж нээлттэй тендер шалгаруулалтын арга ашиглаагүй харьцуулалтын аргаар 6 тендер шалгаруулалтыг зохион байгуулж бусад ажил үйлчилгээнд шууд гэрээ байгуулж худалдан авалт хийсэн байна. Худалдан авах ажиллагааны үр дүнд 20.7 сая төгрөгийн хэмнэлт гаргаж ажилласан байна.

Тайлант онд худалдан авсан бараа ажил үйлчилгээ нь Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуультай нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримтлан ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хатгал тосгоны ТТЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Давааням гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлсэн.

Хатгал тосгоны ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 1/114 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2.0 хувиар тогтоож сонгосон суурь үзүүлэлтээс тооцож 90.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 72.1 сая төгрөгөөр тогтоосон.

Өмнөх онд Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төвүүд улсын төсөвт шилжиж үйл ажиллагааны бус зардлын дүн өндөр байсантай холбоотой тайлант оны нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн өмнөх оноос материаллаг хэмжээгээр буурсан тул Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшнийг тайлант оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 1,144.2 сая төгрөгийг сонгож 18.3 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор харьяа байгууллагуудын төсөвт нийт 229.3 сая төгрөгийн хэмнэлт гарсан байна.

ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой горим сорилыг хэрэгжүүлсэн. Горим сорилыг хэрэгжүүлэх явцад зөрчилтэй асуудал илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй. Худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглан бага үнийн санал ирүүлсэн байгууллагуудтай гэрээ хийж бараа материалыг худалдан авсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 онд гүйцэтгэх завсрын үеийн санхүүгийн аудитын төлөвлөгөөнд тус байгууллагыг хамруулаагүй тул завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 27.1 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмжийг өгсөн байна.

Хүснэгт №-13 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	27.2	2	27.2	100.0
Нийт дүн	2	27.2	2	27.2	100.0

/сая төгрөгөөр/

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал илрээгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 1 төсвийн байгууллага, 1 тусгай сан 1 аж ахуй нэгжийн нийт 4 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллага түүвэрт хамрагдсан байна. Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 185.0 сая төгрөгийн 1 алдаа, 29.3 сая төгрөгийн 1 зөрчил илэрсэн. Аудитын явцад 185.0 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 29.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн байна.

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 29.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс 29.3 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмжийг өгсөн.

Хатгал тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар материаллаг зөрчил илрээгүй тул өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн болно.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарах асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

1. Сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл: ХХОАТ-ын орлого 0.2 сая төгрөгөөр, Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны татвар 12.1 сая төгрөгөөр, шууд бус орлогын албан татвар 1.3 сая төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 0.9 сая төгрөгөөр нийт 14.3 сая төгрөгөөр тасарсан.

2. Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл: Аж ахуй нэгжийн орлогын албан татварын орлогыг 8.4 сая төгрөг, Газрын дуудлага худалдааны орлогыг 0.5 сая төгрөг, Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлогыг 1.9 сая төгрөг нийт 10.8 сая төгрөгөөр тасалсан.

3. Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл: Дотоодын бараа үйлчилгээний НӨАТ-ын орлогыг 4.2 сая төгрөгөөр тус тус тасалсан байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцээгүй бөгөөд Эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлж ажиллах.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5."Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Харьяа байгууллагуудын алдаа /ЗАА/										
Хөрөнгө орлогод аваагүй	1	185,000.0	1	185,000.0			1	185,000.0		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлого бүрдүүлэлттэй холбоотой	1	29,300.0					1	29,300.0
Дүн	1	29,300.0					1	29,300.0
Харьяа байгууллагуудын зөрчил /ЗАА/								
Жолоочийн тооцооны хуудсыг хөтлөхдөө шатахууны илүү дутууг тооцож хяналт тавиагүй, шатахууныг нэр төрлөөр нь бүртгээгүй	1	29,295.9					1	29,295.9

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

БАТАЛГААЖУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Б.ДАВААНЫМ ОГНОО: